

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ГАДААД ЗЭЭЛЛЭГИЙН АШИГЛАЛТ, ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Энэ хуулийн зорилго нь Монгол Улсын Их Хурлаас соёрхон баталсан, үндэсний аюулгүй байдлыг хангах, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 14 мега төслийн жагсаалтад тусгагдсан, импортыг орлох, нийгэм, эдийн засгийн ач холбогдол, үр ашиг бүхий, үйл ажиллагааны орлогоороо зардлаа нөхөх боломжтой, нийслэл Улаанбаатар хотын тулгамдаж буй асуудал болох хүрээлэн буй орчны бохирдол, автозамын түгжрэлийг бууруулах энэ хуульд заасан гадаад зээллэгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төслийн санхүүжилтийн ашиглалтыг холбогдох гэрээ, хэлэлцээрээр тогтоосон хугацаанд ашиглаж, төслийг бүрэн ашиглалтад оруулахад зориулан эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхэд оршино.

Тайлбар: “Гадаад зээллэг” гэдэгт Өрийн удирдлагын тухай хуулийн 4.1.2, 4.1.15-д тус тус заасан гадаад зээл, үнэт цаас зэрэг хөгжлийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэрийг ойлгоно.

2 дугаар зүйл. Энэ хуулиар гадаад зээллэгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан төслийн гадаад зээллэгийн санхүүжилтийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах ба энд зааснаас бусад харилцааг холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.

3 дугаар зүйл. Энэ хуулийн үйлчлэлд гадаад зээллэгийн эх үүсвэрээр хэрэгжүүлж буй доор дурдсан төсөл хамаарна:

3.1. Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл;

3.2. Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл;

3.3. Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төсөл.

4 дүгээр зүйл. Тухайн жилийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлээр батлагдсан нэгдсэн төсвийн нийт зарлага болон нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын хэмжээ энэ хуулийн 3.1-3.3-т заасан нийт төслийн гадаад зээллэгийн санхүүжилтийн ашиглалтын зардлаар нэмэгдэж болох бөгөөд ийнхүү нэмэгдсэн дүн нь дээрх хязгаарт үл хамаарна.

5 дугаар зүйл. Энэ хуулийн энэ хуулийн 3.1-3.3-т заасан нийт төслийн санхүүжилтийн ашиглалтын зардал нэмэгдсэнээр тухайн жилийн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас хэтэрч болно.

6 дугаар зүйл.Тухайн жилийн төсвийн тухай хуулиар батлагдсан гадаад зээлийн санхүүжилтийн ашиглалтын зардал нь энэ хуулийн 3.1-3.3-т заасан нийт төслийн ашиглалтын зардлаар нэмэгдэж болно.

7 дугаар зүйл.Энэ хуулийн 3.3-т заасан төслийн гадаад зээллэгийн санхүүжилтийн ашиглалтын зардал нэмэгдсэн нөхцөлд Төсвийн тухай хуулийн 57.2 дахь хэсэг хамаарахгүй.

8 дугаар зүйл.Засгийн газар нь энэ хуулийн хэрэгжилтийн талаарх тайланг тухайн жилийн төсвийн гүйцэтгэлийн хамтаар хагас жил тутам Улсын Их Хуралд хүргүүлнэ.

9 дүгээр зүйл.Энэ хуулийн 3.1 – 3.3-т заасан төслийн хэрэгжилт, санхүүжилт, төслийн ашиглалттай холбоотой мэдээллийг холбогдох журмын дагуу олон нийтэд тогтмол, ил тод мэдээлнэ.

ГАРЫН ҮСЭГ